



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТЭД 2018 ОНЫ БАЙДЛААР ХИЙСЭН
ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2019 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр
Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
Газрын дарга Б.Ганбат танаа

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2019.01.24

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж байгаа байдалд тавих дотоод хяналт шалгалтыг сайжруулах арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс 18-ны өдрийг дуустал, ажлын 7 өдрийн хугацаанд аудит хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэл, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын 5.3, 5.4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

Дотоод аудитын зорилт:

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг ТӨБЗГ-ын даргын зөвлөлд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлийн хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Хуулийн үйлчлэлд хамаарах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд мэдээлэл хүргэх хэлбэрийг бармтлан, бүрэн хамрагдсан эсэх;
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх;
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлсэн эсэх.

Аудитын цар хүрээ:

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 75 хамруулан шалгалаа. Үүнээс төрийн өмчийн оролцоотой компани 3, төрийн өмчит хувьцаат компани 44, төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компани 7, төрийн өмчит үйлдвэрлэлийн газар 21 байна.

Дотоод аудитын хамрах хугацаа:

2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт (ДАМПОУС) 2300 Аудитын ажлыг гүйцэтгэх, 2310 Мэдээллийг олж тодорхойлох, 2320 Дүн шинжилгээ ба үнэлгээ, 2330 Мэдээллийг баримтжуулах, 2340 Аудитын ажлыг хянан удирдах зэрэг стандартууд болон Нийцлийн аудитын түр журмыг баримтлан хэрэглэгчийн зүгээс шалгагдагч байгууллагын нэгдсэн цахим хуудсанд байрлуулсан мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн оруулсан эсэхэд ажиглалт хийж, мэдээлэл цуглуулах, түүнийг үнэлэх горимыг ашиглалаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу мэдээллээ нэгдсэн системд хуулийн хугацаанд бүрэн оруулсан байх.

Ерөнхий мэдээлэл:

Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий Шилэн дансны тухай хууль 2015 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжиж эхэлсэн.


Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2018 оны байдлаар нийт 7299 байгууллага бүртгэлтэй байгаа бөгөөд системд оруулсан нийт мэдээллийн тоо 2,825,238 байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шилэн дансны хуулийн хэрэгжилтэд 2016, 2017, 2018 оны хагас жилийн байдлаар тус бүр 3 удаа аудит хийж, дүнг тайлагнасан байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилт 2016 оны байдлаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьд 76 хувь, 2017 оны байдлаар 87 хувийн хэрэгжилттэй байсан байна.

Тус аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьд 95 хувь болж өссөн (1 дүгээр хавсралтаар үзүүлэв) нь 2016, 2017 оноос 25 хувь, 9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Өсөлтийг 1 дүгээр графикаар харуулав.

1 дүгээр график



Аудитын үр дүн:

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 75 хуулийн этгээдийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд дараах үр дүнтэй байна. (Шилэн дансны нэгдсэн цахим хуудас (<https://shilendans.gov.mn>)-нд 2019 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар мэдээлэл, тайлангаа байршуулсан байдлыг 1 дүгээр хавсралтаар харуулав).


1. Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, Монгол Улсын засгийн газрын “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” 29 дугаар журмын 2 дахь хэсэгт байгууллага бүр өөрийн цахим хуудсанд шилэн дансны бие даасан цэстэй байхаар заажээ.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах 75 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 100 хувь хамрагдаж, мэдээлэл байршуулах боломжоор хангагдсан байна.

2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллүүдийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах нийт тоо 5,196 байснаас 4,925 мэдээллийг байршуулсан байна.

Үүнээс Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллүүдийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг 100 хувь оруулсан хуулийн этгээд 59 (79 хувь), мэдээлээгүй, дутуу мэдээлсэн хуулийн этгээд 16 (21 хувь) байна. Тухайлбал, мэдээллийг 50-с дээш хувьтай оруулсан хуулийн этгээд 13 (17 хувь), 50-с доош хувьтай оруулсан хуулийн этгээд 2 (3 хувь), хуульд заасан хугацаанд оруулаагүй хуулийн этгээд 1 (1 хувь) байна. Хэрэгжилтийн хувийг 2 дугаар графикаар харуулав.

2 дугаар график



3. Шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээ тайлангаа Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан хугацаанаас олон удаагийн давтамжтайгаар хожимдуулж оруулсан хуулийн этгээд 5 (7 хувь) байна. Үүнд: “Эрдэнэс таван толгой” ХК, “Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨҮГ, “Геологийн төв лаборатори” ТӨҮГ, “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ, Булган аймгийн Хангал суман дахь “Спорт бэлтгэлийн төв” ТӨҮГ.

Дүгнэлт:

Дотоод аудитын үнэлгээг “Хангалттай”, “Сайжруулалт хэрэгтэй”, “Их хэмжээний сайжруулалт хэрэгтэй”, “Хангалттай бус” гэсэн дөрвөн үнэлгээгээр үнэлж, нэгдсэн дүгнэлт болон зөвлөмжийг гаргалаа.

Аудитын үр дүн болон аудитын явцад цуглуулсан нотлох мэдээлэлд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Аудитад хамрагдсан 75 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдсан;
2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болох шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээ тайлангаа оруулсан байдал нь 95 хувийн хэрэгжилттэй байгаа;
3. Тайлан мэдээллээ 50-с доош хувийн хэрэгжилттэй байгаа 3 байгууллага байна.

Энэ нь олон нийтэд ил тод мэдээллээ байршуулах боломжийг бүрдүүлж байгаа боловч мэдээ тайлангаа хуульд заасан хугацаанд бүрэн оруулаагүй байгаа нь олон нийтийн зүгээс мэдээлэлтэй танилцах болон хөндлөнгийн хяналтын байгууллагууд чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байгаа юм.

Тиймээс төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээлдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд **“Сайжруулалт хэрэгтэй”** гэсэн дүгнэлтийг гаргаж байна.

Зөвлөмж:

Аудитын дүн, дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна.

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээ тайлангаа хуульд заасан хугацаанд бүрэн оруулах;
2. Байгууллагын өөрийн цахим хуудас дахь шилэн дансны цэсээ тогтмол шинэчлэн мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэн ажиллах;
3. Байгууллагын удирдлага болон дотоод аудитын алба, нэгжийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулах талаар зөвлөмжийг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 16 хуулийн этгээдэд албан бичгээр тус тус хүргүүлэв.

Дотоод аудитын тайлан боловсруулсан:

Дотоод аудитын мэргэжилтэн

Г.Оюунтөгөлдөр

/2019.02.02/

**Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2018 оны байдлаар мэдээлэл,
тайлан байршуулсан байдал**

№	ТӨХК-ийн мэдээлэл	Мэдээлэх тоо			Мэдээлсэн тоо	Мэдээлээгүй тоо			Хэрэгжилт хувь
		ХО, тендер, ху/авалт	Бусад	Нийт		ХО, тендер, ху/авалт	Бусад	Нийт	
Төрийн өмчийн оролцоотой компани									
1	"Монгол шуудан" ХК	24	36	60	60	0	0	0	100
2	"Эрдэнэс таван толгой" ХК	24	36	60	60	0	0	0	100
3	"Монголын цахилгаан холбоо" ХК	24	36	60	60	0	0	0	100
Төрийн өмчит хувьцаат компани									
4	"Дулааны цахилгаан станц-2" ХК	24	36	60	60	0	0	0	100
5	"Дулааны цахилгаан станц-3" ХК	24	36	60	60	0	0	0	100
6	"Дулааны цахилгаан станц-4" ХК	24	36	60	60	0	0	0	100
7	"Дарханы дулааны цахилгаан станц" ХК	24	36	60	60	0	0	0	100
8	"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ХК	24	36	60	60	0	0	0	100
9	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ХК	24	36	60	60	0	0	0	100
10	"Улаанбаатар дулааны сүлжээ" ХК	24	36	60	60	0	0	0	100
11	"Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ХК	24	36	60	60	0	0	0	100
12	"Дарханы дулааны сүлжээ" ХК	24	36	60	60	0	0	0	100
13	"Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" ХК	24	36	60	60	0	0	0	100
14	"Дорнод бүсийн эрчим хүчний систем" ХК	24	36	60	58	0	2	2	97
15	"Даланзадгадын дулааны цахилгаан станц" ХК	24	36	60	60	0	0	0	100
16	"Багануур-Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ХК	24	36	60	60	0	0	0	100
17	"Баруун бүсийн эрчим хүчний систем" ХК	24	36	60	59	0	1	1	98
18	"Багануурын дулааны станц" ХК	24	36	60	60	0	0	0	100
19	"Налайхын дулааны станц" ХК	24	36	60	60	0	0	0	100
20	"Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ХК	12	36	48	48	0	0	0	100
21	"Алтай-Улиастай эрчим хүчний систем" ХК	24	36	60	59	0	1	1	98
22	"Дулаан шарын гол" ХК	24	36	60	60	0	0	0	100
23	"Ховд дулааны станц" ХК	24	36	60	60	0	0	0	100
24	"Хөвсгөл дулааны станц" ХК	24	36	60	60	0	0	0	100
25	"Улаангомьын дулааны 2 дугаар станц" ХК	24	36	60	60	0	0	0	100
26	"Баянчандмань АЗЗА" ХК	24	36	60	60	0	0	0	100
27	"Налайх АЗЗА" ХК	24	36	60	60	0	0	0	100
28	"Дархан АЗЗА" ХК	24	36	60	60	0	0	0	100
29	"Сэлэнгэ АЗЗА" ХК	24	36	60	60	0	0	0	100

№	ТӨХК-ийн мэдээлэл	Мэдээлэх тоо			Мэдээлсэн тоо	Мэдээлээгүй тоо			Хэрэгжилт хувь
		ХО, тендер, ху/авалт	Бусад	Нийт		ХО, тендер, ху/авалт	Бусад	Нийт	
30	"Дорноговь АЗЗА" ХК	24	36	60	60	0	0	0	100
31	"Төв АЗЗА" ХК	24	36	60	59	1	0	1	98
32	"Эрдэнэсант АЗЗА" ХК	24	36	60	60	0	0	0	100
33	"Багануур АЗЗА" ХК	24	36	60	59	0	1	1	98
34	"Харгуй" ХК	24	36	60	60	0	0	0	100
35	"Талын зам" ХК	24	36	60	60	0	0	0	100
36	"Хархорин АЗЗА" ХК	24	36	60	60	0	0	0	100
37	"Өвөрхангай АЗЗА" ХК	24	36	60	60	0	0	0	100
38	"Архангай АЗЗА" ХК	24	36	60	60	0	0	0	100
39	"Булган АЗЗА" ХК	24	36	60	60	0	0	0	100
40	"Орхон АЗЗА" ХК	24	36	60	57	2	1	3	95
41	"Хөвсгөл АЗЗА" ХК	24	36	60	60	0	0	0	100
42	"Ховд АЗЗА" ХК	24	36	60	60	0	0	0	100
43	"Увс АЗЗА" ХК	24	36	60	60	0	0	0	100
44	"Говь-Алтай АЗЗА" ХК	24	36	60	60	0	0	0	100
45	"Завхан АЗЗА" ХК	24	36	60	55	2	3	5	92
46	"МИАТ" ХК	24	36	60	60	0	0	0	100
47	"Монголын төмөр зам" ХК	24	36	60	60	0	0	0	100
Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани									
48	"Эрдэнэт үйлдвэр" ХХК	24	36	60	45	4	11	15	75
49	"Монголросцветмет" ХХК	24	36	60	60	0	0	0	100
50	"Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК	24	36	60	60	0	0	0	100
51	"Диспетчерийн үндэсний төв" ХХК	24	36	60	60	0	0	0	100
52	"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ХХК	24	36	60	6	21	33	54	10
53	"Хөдөө аж ахуйн бирж" ХХК	12	36	48	48	0	0	0	100
54	"Эгийн голын усан цахилгаан станц" ХХК	24	36	60	60	0	0	0	100
Төрийн өмчит үйлдвэрийн газар									
55	"Монгол кувейтын байгаль хамгаалах төв" ТӨҮГ	36	60	96	96	0	0	0	100
56	"Аялал жуулчлалын хөгжлийн төв" ТӨҮГ	36	24	60	19	36	5	41	32
57	"Геологийн төв лаборатори" ТӨҮГ	36	60	96	88	8	0	8	92
58	"Геологийн судалгааны төв" ТӨҮГ	36	60	96	96	0	0	0	100
59	"Монгол кино нэгтгэл" ТӨҮГ	36	60	96	67	12	17	29	70
60	ЦЕГ-ын харьяа "Цагаан шонхор" ТӨҮГ	36	60	96	96	0	0	0	100
61	"Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв" ТӨҮГ	36	60	96	96	0	0	0	100
62	"Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ	36	60	96	95	0	1	1	99
63	"Монгол Ус" ТӨҮГ	36	60	96	96	0	0	0	100
64	"Барилга хөгжлийн төв" ТӨҮГ	36	60	96	84	0	12	12	88
65	"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ	36	60	96	96	0	0	0	100
66	"Төрийн орон сууцны корпораци" ТӨҮГ	36	60	96	96	0	0	0	100

№	ТӨХК-ийн мэдээлэл	Мэдээлэх тоо			Мэдээлсэн тоо	Мэдээлээгүй тоо			Хэрэгжилт хувь
		ХО, тендер, ху/авалт	Бусад	Нийт		ХО, тендер, ху/авалт	Бусад	Нийт	
67	"Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨҮГ	36	60	96	96	0	0	0	100
68	"Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨҮГ	36	60	96	96	0	0	0	100
69	Булган аймгийн Хангал суман дахь "Спорт бэлтгэлийн төв" ТӨҮГ	36	60	96	96	0	0	0	100
70	"Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ	36	60	96	96	0	0	0	100
71	"Буянт Ухаа спортын ордон" ТӨҮГ	36	60	96	95	1	0	1	99
72	"Техник спортын төв" ТӨҮГ	36	60	96	0	36	60	96	-
73	"Мэдээлэл технологийн үндэсний парк"	36	60	96	96	0	0	0	100
74	"Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" ТӨҮГ	36	60	96	96	0	0	0	100
75	"Чингис хаан олон улсын нисэх буудал" ТӨҮГ	36	60	96	96	0	0	0	100
Нийт дүн		2028	3168	5196	4925	123	148	271	95

---oOo---